

**НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,938,000.00	1,656,684.00	281,316.00	85%
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	250,000.00	-	100%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	134,984.00	265,016.00	34%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	88,000.00	-	100%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,200,000.00	1,183,700.00	16,300	97%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,210,000.00	8,132,140.00	77,860	99%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,960,000.00	6,882,140.00	77,860	99%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,250,000.00	1,250,000.00	-	100%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,000,000.00	11,993,000.00	7,000	100%
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-	-	
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,000,000.00	11,993,000.00	7,000	100%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,000,000.00	11,993,000.00	7,000	100%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,355,172,400.00	1,349,724,224.06	5,448,175.94	99.6%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,355,172,400.00	1,349,724,224.06	5,448,175.94	99.6%
132001	Орон нутгийн төсвөөс	1,355,172,400.00	1,349,724,224.06	5,448,175.94	99.6%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	31	31	-	100%
620001	Удирдах ажилтан	1	1	-	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	23	23	-	100%
620003	Үйлчлэх ажилтан	7	7	-	100%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	240,782,299.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	240,782,299.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	240,782,299.09
2104	Хангамж, бараа материалын зардал	19,500,899.09
210402	Тээвэр, шатахуун	1,270,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,930,899.09
2105	Нормативт зардал	143,628,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	19,554,500.00
210502	Хоол, хүнс	99,413,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	24,660,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,730,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,240,000.00
210602	Тавилга	490,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,923,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,923,200.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	240,782,299.09
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	240,782,299.09
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	31,696,899.09
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	209,085,400.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийгмийн хамгааллын тусгай төв нь "21-ээс дээш насны гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдэд түр хоноглох байраар үйлчилж, хоол хүнс, хувцас хэрэглэлээр ханган, эрүүл мэндийн анхан шатны тусламж, хувь хүний хөгжил төлөвшил, нийгэм сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээ, нийгмийн халамжийн суурь үйлчилгээнд хамруулан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр бие даасан амьдралд шилжихэд нь дэмжин туслах зорилготой" гэж тодорхойлсон Нийслэлийн харъяа төсөвт байгууллага юм. Нийгмийн хамгааллын тусгай төв нь тайлант жилийн үйл ажиллагааны зорилгоо "Нийт үйлчлүүлэгч иргэдийн таван хувийг бие даасан амьдралд шилжүүлнэ" гэж тодорхойлон,

- Хүний эрх, эрх чөлөө;
- Үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх;
- Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжүүлэх;
- Ил тод, нээлттэй байдал гэсэн 4 зорилтыг дэвшүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Нийгмийн хамгааллын тусгай төвийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд тайлант онд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын багц хууль шинээр батлагдсан;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /шинэчилсэн найруулга/;
- ЗГ-ын 2024 оны 128 дугаар тогтоол "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн батлах тухай";
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 дахь заалт хүчингүй болсон.

Тус байгууллагад дотоод аудитын алба байхгүй бөгөөд орон тооны бус ажилтан ажилладаг. Байгууллагын дотоод хяналтын батлагдсан журам, төлөвлөгөөний дагуу ажилтнуудын 16 чиглэлээр 20 ажилтны хариуцсан ажлын бичиг баримтын хөтлөлт, бүрдүүлэлтэд хяналтын ажлыг чиг үүргийн дагуу холбогдох ажилтантай хамтран гүйцэтгэсэн байна.

Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны санхүүгийн чиг үүргийг удирдах дээд шатны ажилтнууд хэрэгжүүлдэг байна. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нийгмийн хамгааллын тусгай төв нь төвийн даргын баталсан 2021 оны "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 2 дугаар хавсралтын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 46,232.7 мянган төгрөгөөр буюу 3.47 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	113,338.6	169,476.5	56,137.9
Үндсэн хөрөнгө	1,172,569.6	1,162,664.4	(9,905.2)
Нийт хөрөнгө	1,285,908.2	1,332,140.9	46,232.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,285,908.2	1,332,140.9	46,232.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,285,908.2	1,332,140.9	46,232.7

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

Бараа материал дансны үлдэгдэл 169,476.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 56,137.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хүнсний материал 35,449.3 мянган төгрөг, тусгай зориулалтай материал 7,772.9 мянган төгрөг, аж ахуйн материал 5,192.7 мянган төгрөг, бусад хангамжийн материал 4,024.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,162,664.4 мянган төгрөг болж 9,905.2 мянган төгрөгөөр буурсан нь 60,377.5 мянган төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна. 2024 онд 50,472.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, 13,112.6 мянган төгрөгийн хөрөнгийг Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/653 дугаар тушаалын дагуу данснаас хассан нь нөлөөлсөн байна. Биет бус хөрөнгөнд өөрчлөлт ороогүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 954,172.5 мянган төгрөг, нийт зарлагыг 954,172.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 400,999.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 1,355,172.4 мянган төгрөгөөр баталжээ. Энэ нь 2024 оноос цалин нэмэгдсэнтэй холбоотойгоор цалин хөлс, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг нийт 400,999.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,355,172.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,355,172.4 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 1,349,724.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,349,724.2 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	71902- Нийгмийн халамж хөтөлбөр	1,355,172.4	1,349,724.2	5,448.2	99.6
1-1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	1,343,172.4	1,337,731.2	5,441.2	99.6
1-2	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	12,000.00	11,993.0	(7.0)	99.9
	ДҮН	1,355,172.4	1,349,724.4	5,448.2	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нийгмийн хамгааллын тусгай төв нь тайлант онд нийт 240,782.3 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийг авсан байна.

- Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 116,728.4 мянган төгрөг, Нийслэлийн Засаг даргын тамгын газраас 22,918.0 мянган төгрөг, Аддиктологийн төвөөс 69,439.0 мянган төгрөг, Канадын элчин сайдын санхүүжүүлэх төсөл хөтөлбөрөөс 31,696.9 мянга, нийт 240,782.3 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Зарцуулалтыг дэлгэрэнгүй харуулахад;

- Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын 2024 оны А/89 дугаар захирамжаар "Архины хамааралтай, гэр оронгүй тэнэмэл иргэдийг нийгэмшүүлэх цогц арга хэмжээ" зохион байгуулсан;
- Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1511 дүгээр захирамжаар "Гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдийн талаар авах зарим арга хэмжээ" зохион байгуулсан;

- Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1183 дугаар захирамжаар Аддиктологийн төв, Нийслэлийн Цагдаагийн газартай хамтран Тэнэмэл орон гэргүй, архины хамааралтай, орчиндоо түгшүүр төрүүлдэг иргэдийг нийгэмшүүлэх, архинаас татгалзуулах, эмийн болон сэтгэл зүйн чиглэлээр эмчилгээнд хамруулах "ИТГЭЛ-2024" төслийг зохион байгуулсан;
- Канадын элчин сайдын яамнаас санхүүжүүлсэн "Сэргээн засах, чийрэгжүүлэх танхим байгуулах" төслийг амжилттай хэрэгжүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Нийгмийн хамгааллын тусгай төв нь тайлант онд урсгал үйл ажиллагааны төсвөөс 471,009.7 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг хийж гүйцэтгэсэн байна.

Үүнээс: Хүнсний материал худалдан авах тендерт шалгарсан 3 аж ахуйн нэгжээс 155,022.3 мянган төгрөгийн хүнсний материал, тендерийн үнэлгээний хорооноос гарсан зөвлөмжийн дагуу харьцуулалтын аргаар 1 аж ахуйн нэгжээс 133,049.4 мянган төгрөгийн хүнсний материал, 19,850.0 мянган төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмжийг 1 аж ахуйн нэгжээс, шууд худалдан авалтын аргаар 163,088.0 мянган төгрөгийн бараа материал, тавилга, тоног төхөөрөмжийн худалдан авалтыг 17 аж ахуйн нэгж болон иргэнтэй хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Нийгмийн хамгааллын тусгай төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах, санхүүгийн программ хангамжийн аюулгүй байдалд анхаарах, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн аудитор Ц.Цэнд-Аюуш гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер С.Гантөгс, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр, дэд дарга Ч.Болд нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийгмийн хамгааллын тусгай төв нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нийслэл дэх Төрийн газарт 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн

тайланг, суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 872,217.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 13,083.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласнаар цалин, хөлстэй холбоотой зардлыг 3,633.9 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1,200.7 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 246.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 281.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 77.9 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 7.0 мянган төгрөгөөр, нийт 5,441.2 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 127,025.7 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийгмийн хамгааллын тусгай төв нь Шилэн дансны цахим хуудсанд цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,475,951.3 мянган төгрөгийн 23 гүйлгээг, зарлагын 402,728.3 мянган төгрөгийн 80 гүйлгээг хуулийн хугацаанд мэдээлж, 124,996.4 мянган төгрөгийн 1 орлогын гүйлгээ дутуу мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.5-д цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;” гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулж хэвших;

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй тайлант онд албан хэрэгцээнд 2,029.3 мянган төгрөгийн бараа материал цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй Зөв өнгө ХХК, Үндсэн өнгө ХХК-иас шууд худалдан авалт хийсэн байна.

УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх; Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-д "Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна." гэж заасантай нийцээгүй байна.

Зөвлөмж: Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авах бараа, үйлчилгээг цахим дэлгүүрээс худалдан авч байх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн Нийгмийн хамгааллын тусгай төвийн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийж, илэрсэн зөрчлийг асуудлын бүртгэлээр танилцуулж, 190,588.4 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгснийг шалгахад тайлант хугацаанд залруулсан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 9,255.6 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт
/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	9,255.6	1	9,255.6	100.0
Нийт дүн	1	9,255.6	1	9,255.6	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар цахим дэлгүүрээс худалдан авалт хийх зохицуулалттай төсвийн зарцуулалт, түүний үр нөлөөтэй байдалд анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,253.8 мянган төгрөгийн 3 зөрчлийг илрүүлж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа зөрчлөөс 5,253.8 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 7,829.5 мянган төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгөхийг санал болголоо.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Бараа материалын орлогын болон зарлагын баримтад хүлээн авсан, хүлээлгэн өгсөн хүний гарын үсэггүйгээр 4,939.4 мянган төгрөгийн гүйлгээ хийж, данс бүртгэлд тусгасан байна.

Энэ нь УСНББОУС-29 Санхүүгийн хэрэглүүр, хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2-д "Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх, дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүйгээр тусгасан байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орлого, зарлагын баримтыг хүлээн авсан, хүлээлгэн өгсөн, хянаж, шалгасан ажилтны гарын үсгээр баталгаажуулж, анхан шатны баримтын иж бүрдлийг хангаж ажиллах;

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-2: Цалингийн хүснэгтийг НДШ-ийн тайлантай тулган шалгахад 4 хүний 125.7 мянган төгрөгийн НДШ-ийг илүү, ХХОАТ-ыг 188.7 мянган төгрөгөөр илүү суутган тайлагнасан байна.

Энэ нь УСНББОУС-19 Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална:" 5.1.4-д "үнэн зөв байх" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалингаас тооцсон НДШ, ХХОАТ-ын өглөг, авлагыг зөв тооцсон, баримтанд үндэслэн үнэн зөв тайлагнаж байх;

Илрүүлэлт-3: Санхүүгийн программ хангамж нь мэдээллийн аюулгүй байдлын SSL сертификат ашигладаггүй байна. Энэ нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.3-д "Мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар стандарт нэвтрүүлэх", 19.2.4

“Кибер аюулгүй байдлын хангах үйл ажиллагаа хариуцсан нэгж эсхүл албан тушаалтантай байх” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын санхүүгийн программ хангамжийн системийн аюулгүй байдлыг эрсдэлээс хамгаалах арга хэмжээг зохион байгуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж, данс бүртгэлд тусгасан.	1	4,939.4					1	4,939.4				
Цалингийн хүснэгтээс 4 хүний НДШ-ийг илүү суутгаж, ХАОАТ-ын тайлан зөрүүтэй илэрхийлсэн байна.	1	314.4					1	314.4				
Санхүүгийн программ хангамжийн SSL сертификат ашигладаггүй.	1	-					1	-				
Дүн	3	5,253.8					3	5,253.8				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/ мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим хуудсанд орлогын 1 гүйлгээ мэдээлээгүй байна.	1	124,996.4					1	124,996.4
Цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.	1	2,029.3					1	2,029.3
Дүн	2	127,025.7					2	127,025.7